



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/397

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газартай хамтран зохион байгуулсан баруун таван аймгийн төлөөлөл оролцсон “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийг ашиглах нь” сэдэвт сургалтын арга хэмжээний зардалд 1 050 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 050 000 төгрөг /Нэг сая тавин мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг Даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар  
сарын 25-ны өдрийн А/397 дугаар  
захирамжийн хавсралт



**“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГАЧЛАЛ, ЦАХИМ  
СИСТЕМИЙГ АШИГЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Д.д	Зардлын төрөл, зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Үдийн хоол (цай, 1-р хоол, 2-р хоол, салат)	ш	45	23.300	1 052.0
	НИЙТ ДҮН				1 052.0

-oOo-